



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 21 өдөр


Дугаар A/160

Улаанбаатар хот

Цахим болон тоон гарын үсэгт шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Цахим гарын үсгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 73 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 111 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичиг, албан хэрэг хөтлөлтийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс тоон гарын үсэгт шилжүүлэн цахимаар мэдээлэл солилцох талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг харьяа газар, байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулахад бодлогын удирдамжаар хангаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар /Д.Гэрэлням/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар/М.Энхболд/-т даалгасугай.



081188